

СОЁЛЫН САЙД, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,
САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны 04 сарын
09-ны өдөр

Дугаар А/166, А/63, А/73

Улаанбаатар хот

Шалгуур үзүүлэлт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Соёлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Журам батлах тухай" 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Шалгуур үзүүлэлтийн дагуу тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд багтаан соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгохыг холбогдох төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.

СОЁЛЫН САЙД


Ч.НОМИН

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

Х.БУЛГАНТУЯА



**СОЁЛ, УРЛАГИЙН САЛБАРЫН ТӨРИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧИД УР ЧАДВАРЫН
НЭМЭГДЭЛ ОЛГОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

1. Соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын (ТҮСБ) зэрэглэлийн удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалд ажиллаж байгаа соёлын ажилтанд ур чадварын нэмэгдэл олгоход энэхүү шалгуур үзүүлэлтийг мөрдөнө.
2. Ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвх санаачилгатай, үр бүтээлтэй ажилласан байдлыг харгалзан ёс зүйн зөрчилгүй, сахилгын шийтгэлгүй, соёлын ажилтанд шалгуур үзүүлэлтийг баримтлан ур чадварын нэмэгдлийг олгоно.
3. Ур чадварыг үнэлж дүгнэх, нэмэгдэл олгох үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй, шударга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.
4. Соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний ажилтны (цаашид “соёлын ажилтан” гэх) ажлыг дараах байдлаар үнэлгээг тодорхойлж дүгнэнэ.
 - 4.1. Соёлын удирдах албан тушаалд ажиллаж буй ажилтныг дүгнэхдээ Манлайлах чадвар, мэргэжил, арга зүйн чадвар, ажлын арга барил, асуудал шийдвэрлэх чадвар зэрэг 3 шалгуурыг үзүүлэлт тус бүрийн 10 оноогоор;
 - 4.2. Соёлын гүйцэтгэх албан тушаалд ажиллаж буй ажилтныг дүгнэхдээ -Ажил гүйцэтгэх чадварын шалгуурыг үзүүлэлт тус бүрийн 15 оноогоор, ажлын арга барил шалгуурыг үзүүлэлт тус бүрийн 10 оноогоор;
 - 4.3. Соёлын туслах албан тушаалд ажиллаж буй ажилтныг дүгнэхдээ -Ажлын арга барил шалгуур үзүүлэлт тус бүрийн 25 оноогоор.
5. Соёлын ажилтны ажлыг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ:
 - 5.1. Соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний удирдах (театр, чуулгын захирал, үндэсний соёлын байгууллага, музейн захирал болон нэгжийн дарга, соёлын төвийн дарга нар буюу ТҮСБ-5, ТҮСБ-6, ТҮСБ-7 зэрэглэлд хамаарах удирдах) албан тушаалтан;

№	Шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээ оноо	Нийт Үнэлгээ
1	Манлайлах чадвар	Ажилтны үр бүтээлтэй ажиллах орчин нөхцөл, нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдал	10	50
		Үйлчлүүлэгчийн тав тух, соёлын хүртээмж орон зай, уран бүтээлийн чанар, сэтгэл ханамжийг бүрдүүлсэн байдал	10	

		Авьяас билэг, ур чадвар, мэргэжлийн туршлагаар манлайлсан байдал	10	
		Хамт олны төлөвшил, байгууллагын соёлд гарсан өөрчлөлт	10	
		Төсөв, санхүү, эд хөрөнгийн зөрчилгүй байх	10	
2	Мэргэжил, арга зүйн чадвар	Мэдлэг, туршлагаа хуваалцах чадвар	10	30
		Ажилтны мэргэжил, арга зүйн хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт	10	
		Эрхэлсэн ажил үүргээ мэргэжлийн түвшинд гүйцэтгэсэн байдал	10	
3	Ажлын арга барил, асуудал шийдвэрлэх чадвар	Шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулж, асуудал шийдвэрлэсэн байдал	10	20
		Соёлын үйлчилгээний хүртээмжид гарсан ахиц, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл	10	

5.2.Соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний удирдах (уран сайхны удирдагч, ерөнхий найруулагч, ерөнхий удирдаач, ерөнхий балетмейстер, ерөнхий номын санч буюу ТҮСБ-5, ТҮСБ-6, ТҮСБ-7 зэрэглэлд хамаарах удирдах) албан тушаалтан;

№	Шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээ оноо	Нийт Үнэлгээ
1	Манлайлах чадвар	Авьяас билэг, ур чадвар, мэргэжлийн туршлагаар манлайлсан байдал	10	50
		Хариуцсан ажлаа цаг үеийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн гүйцэтгэсэн байдал	10	
		Соёлын үйл ажиллагааны чиглэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байдал, үр дүн	10	
		Хамт олны дунд хүлээн зөвшөөрөгдсөн байдал	10	
		Эрхэлсэн ажлын чиглэлээр зөрчил, доголдол гаргаагүй байх	10	
2	Мэргэжил, арга зүйн чадвар	Бүтээлч байдал, шинэчлэг санал, санаачилга гаргасан байдал, хэрэгжилт, үр дүн	10	30
		Ажилтны мэргэжил, арга зүйн хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт	10	
		Соёл, урлаг, уран бүтээлийн эрхэлсэн ажил үүргээ мэргэжлийн түвшинд гүйцэтгэсэн байдал	10	
3	Ажлын арга барил, асуудал шийдвэрлэх чадвар	Шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулж, асуудал шийдвэрлэсэн байдал	10	20
		Соёлын үйлчилгээний хүртээмжид гарсан ахиц, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл	10	

5.3.Соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний гүйцэтгэх (ТҮСБ-2, ТҮСБ-3,ТҮСБ-4, ТҮСБ-5, ТҮСБ-6 зэрэглэлд хамаарах гүйцэтгэх) албан тушаалтан;

№	Шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээ	Нийт
---	---------	----------	---------	------

			оноо	Үнэлгээ
1	Ажил гүйцэтгэх чадвар	Авьяас билэг, мэргэжлийн ур чадвар, туршлагаа хөгжүүлсэн байдал	15	60
		Өөрийн туршлага, мэдлэг чадвараар бусдад үлгэрлэн, түгээсэн байдал	15	
		Бүтээлч, шинэлэг санаачилга гаргасан байдал, хэрэгжилт, үр дүн	15	
		Эрхэлсэн ажлын чиглэлээр зөрчил, доголдол гаргаагүй байх	15	
2	Ажлын арга барил	Шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулж, асуудал шийдвэрлэсэн байдал (үйлчлүүлэгч, эрдэмтэн судлаачийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан байх)	10	40
		Ажлын гүйцэтгэлд гарсан ахиц, үр дүн	10	
		Соёл урлагийн орчин бүрдүүлэхэд үзүүлсэн бүтээлч байдал, иргэдэд үзүүлсэн төрийн үйлчилгээ	10	
		Хамт олны дунд хүлээн зөвшөөрөгдсөн байдал	10	

5.4. Соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний туслах (ТҮСБ-1, ТҮСБ-2 зэрэглэлд хамаарах туслах) албан тушаалтан;

№	Шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээ оноо	Нийт Үнэлгээ
1	Ажил гүйцэтгэх чадвар	Албан тушаалын чиг үүргээ чанартай, үр бүтээлтэй гүйцэтгэсэн байдал	25	100
		Соёл урлагийн орчин бүрдүүлэхэд үзүүлсэн бүтээлч байдал, иргэдэд үзүүлсэн төрийн үйлчилгээний чанар, хүртээмж	25	
		Эрхэлсэн ажлын чиглэлээр зөрчил, доголдол гаргаагүй байх	25	
		Өөрийн хариуцаж буй техник, хэрэгслийн бүрэн бүтэн байдал	25	

6. Соёлын ажилтны ур чадварын нэмэгдлийг тухайн улирлын сүүлийн сарын 20-ны дотор үнэлсэн үнэлгээнд үндэслэн дараагийн улирлын нэмэгдлийг сар бүр олгоно.

7. Шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 60.0 болон түүнээс дээш хувийг хангасан соёлын ажилтанд тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан ур чадварын нэмэгдэл олгоно.

8. Соёлын ажилтны ур чадварыг үнэлж дүгнэх, нэмэгдлийн хэмжээг тогтоох, нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын удирдлагын шийдвэрээр байгуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн төсвийн шууд захирагч шийдвэрлэнэ. Хэрэв тухайн байгууллага 15 түүнээс доош албан хаагчтай бол төсвийн шууд захирагч үнэлж шийдвэрлэнэ.

9. Соёл, урлагийн салбарын удирдах албан тушаалтан буюу төсвийн шууд захирагч нарын ур чадварын нэмэгдлийг соёл, урлагийн газрын дарга үнэлж, дүгнэн шийдвэрлэнэ.

10. Шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 60.0 болон түүнээс дээш үнэлгээ авсан албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 10-25 хувиар тооцож, нэмэгдлийг дараах хувиар тогтооно.

60-69 оноо	70-79 оноо	80-89 оноо	90-100 оноо
10%	15%	20%	25%

11. Ур чадварыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэхдээ ажилтны ажилласан хугацаанд ногдуулж олгоно.

12. Соёлын ажилтан ур чадварын нэмэгдэл олгох үнэлгээг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд дээд шатны удирдлагад гомдол гарган шийдвэрлүүлэх эрхтэй.

13. Соёлын ажилтны ур чадварын нэмэгдлийг зөвхөн албан хаагчийн ур чадвар, шалгуурыг үндэслэн олгох бөгөөд бусад нөхцөл байдлыг харгалзан олгохыг хориглоно.

---oOo---